



АРДЫН ЖУЖИГЧИН, ТӨРИЙН ШАГНАЛТ
Ц.НАМСРАЙЖАВЫН НЭРЭМЖИТ
**УЛСЫН ФИЛАРМОНИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Улсын Филармонийн уран бүтээлч, ажилтны
ёс зүйн дүрэм батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйийн 43.1.6 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. “Улсын Филармонийн уран бүтээлч, ажилтны ёс зүйн дүрэм”-ийг хавсралт
ёсоор баталж, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. “Улсын Филармонийн уран бүтээлч, ажилтны ёс зүйн дүрэм”-ийг нийт
ажилтнуудад танилцуулахыг хэлтэс, алба, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тус дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, чанд сахин ажиллахыг
нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

4. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, ёсзүйн дэд хороон дарга (Г.Алтан-Од)-д
үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улсын Филармонийн захирлын
тушаалаар баталсан 2023 оны A/09 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



С.БАТТУЛГА

Улсын филарманийн захирлын 2025 оны
05 дугаар сарын 16-ны өдрийн
А/15 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ФИЛАРМОНИЙН УРАН БҮТЭЭЛЧ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ёс зүйн дүрмийн зорилго нь уран бүтээлч, ажилтнаас Филарманийн үнэт зүйлс, зарчмыг дээдлэн сахих, уран бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэхэд оршино.

1.2. Энэхүү дүрэм нь "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Соёлын тухай хууль", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030", "Улсын Филарманийн дүрэм", "Хөдөлмөрийн дотоод журам" бусад холбогдох хууль дүрэм журмын хүрээнд үйлчилнэ.

1.3. Ёс зүйн дүрэм нь хууль дүрмээр олгогдсон албан үүрэг, эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хамт олон, нийгмийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлдлийн нийлбэр цогц юм.

1.4. Энэхүү хэм хэмжээгээр байгууллагын эрх ашгийг эн тэргүүнд тавьж үйл ажиллагаанд уран бүтээлч, ажилтныг хариуцлагатай оролцуулах, шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, байгууллагын соёлыг хэвшүүлэн ёс зүйн зөрчилгүй хамт олон болоход чиглүүлж ажиллана.

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. Уран бүтээлч гэдэгт уран бүтээлийн хэлтсийн дарга, уран сайхны удирдагч, удирдаач, найруулагч, хөгжмийн зохиолч, дуучин, концертмейстр, хөгжимчин, хөөмийч, нотны бичээч, инспектор хамаарна.

2.1.2. Ажилтан гэдэгт Улсын Филарманийн бүтцийн нэгжүүдэд хамаарах ажиллах нийт ажилтан хамаарна.

2.1.3. Уран бүтээлч, ажилтны ёс зүйн хэм хэмжээ гэж эзэмшсэн мэргэжилдээ үнэнч байж, урлагийн ажилтны нэр хүндийг хамгаалах, энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг чанд биелүүлэх талаар тогтоосон шаардлагыг хэлнэ.

Гурав. Улсын Филарманийн уран бүтээлч, ажилтны
эрхэмлэх үнэт зүйлс, зарчим

3.1. Уран бүтээлч, ажилтан нь Улсын Филарманийн үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ.

Улсын Филарманийн үнэт зүйлс нь:

- Уламжлал ба шинэчлэл
- Үзэгч, сонсогч
- Бүтээлч, чадварлаг хамт олон
- Ухамсар, ёс зүй

3.2. Улсын Филарманийн уран бүтээлч, ажилтан үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 3.2.1. Шударга, үнэнч байх;
- 3.2.2. Хүнлэг энэрэнгүй байх;
- 3.2.3. Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 3.2.4. Соёлтой харилцааг эрхэмлэх;
- 3.2.5. Багаар хамтран ажиллах чадвартай хамтач байх;
- 3.2.6. Хариуцлагатай байх;
- 3.2.7. Манлайлах;

3.3. Улсын Филарманийн үнэт зүйлс, зарчмыг уран бүтээлч, ажилтан өөрийн үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах үүрэгтэй.

Дөрөв. Уран бүтээлч, ажилтанд тавигдах нийтлэг
ёс зүйн хэм хэмжээ

4.1. Уран бүтээлч, ажилтан нь төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйл, энэ дүрмийн 3.1, 3.2-т заасан үнэт зүйлс, зарчимд нийцсэн дараах ёс зүйн хэм хэмжээг чандлан сахина.

4.1.1. Хамт олон, үзэгч сонсогч бусад хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

4.2.2. Төрт ёс, түүх, соёлын өв, уламжлал шинэчлэлээс суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх;

4.2.3. Байгууллагын нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

4.2.4. Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

4.2.5. Ажил төрлийн холбогдолтой бодитой шүүмжлэл, саналыг хүлээн авч, алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрч, засдаг байх;

4.2.6. Удирдах албан тушаалтан, уран бүтээлч, ажилтан, үзэгч, сонсогч болон бусад иргэд, хамтран ажиллагдынхаа нэр төрд халдах зорилгоор худал мэдээлэл нийтэд тараах, хувь хүний нууцад халдах, хэл амаар доромжлох, заналхийлэх, бүдүүлэг зан авир гаргах, дарамтлах зэрэг аливаа үйлдэл гаргахгүй байх;

4.2.7. Өөрт илэрхий болсон албаны нууцыг чандлан хадгалдаг байх;

4.2.8. Гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандаа дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

4.2.9. Хувийн ашиг сонирхлын үүднээс хамтран ажиллагч иргэн, байгууллага, үзэгч, сонсогч, үйлчлүүлэгчээс шан харамж, бэлэг сэлт, ажил, үйлчилгээ авах, авахаар шахаж шаардах, зуучлах, хувийн ажлаа гүйцэтгүүлэх, удирдлага дор ажиллаж байгаа уран бүтээлч, ажилтанд бараа бүтээгдэхүүн борлуулах, авахыг санал болгох;

4.2.10. Улсын Филармонийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, бусад актуудад тусгасан үүргийг чандлан сахиж баримталдаг байх;

4.2.11. Ажлын байрны бэлгийн дарамтаас ангид байх;

4.2.12. Албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх;

4.2.13. Авьяас чадвар, мэдлэг, боловсролоо байнга дээшлүүлэхийн төлөө өөрийн хүчээ дайчлан бүтээлчээр ажиллаж, аливаа асуудалд шинэлэг сэтгэлээр хандаж, авьяас чадвараараа шударга өрсөлдөх;

4.2.14. Оюуны өмч, зохиогчийн эрх, бусдын бүтээл, байгууллагын өмч хөрөнгийг хууль бусаар өөрийн болгох зэрэг оюун санааны цэвэр ариун байх тогтсон ёс дэгийг зөрчихгүй байх;

4.2.15. Байгууллагын урын санд хадгалагдаж буй нот партитурыг бусдад хэрэглүүлэх, шилжүүлэх, худалдан борлуулах, борлуулахаар шахалт үзүүлэхгүй байх;

4.2.16. Хамтран ажиллагч иргэн, байгууллага, хамтран ажиллагчдаа хувийн үзэл бодол, улс төрийн байр сууриа тулган хүлээлгэхгүй, уриалахгүй байх;

4.2.17. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлж, ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглах;

4.2.18. Ажлын туршлага мэдлэг боловсролоо, бусадтай хуваалцан байгууллагын эрх ашгийг нэн түрүүнд тавьж, хамт олны эв нэгдлийг дээдлэх;

4.2.19. Байгууллагын бүтэц, ажлын байрны тодорхойлолтын дагуу удирдах, удирдуулах ёсыг баримтлах;

4.2.20. Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;

4.2.21. Үнэн зөв болох нь мэдэгдэхгүй хов, цуу ярианд автахгүй байж зөвхөн баттай эх сурвалжаас авсан мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах;

4.2.22. Хүний эмзэг болон хувийн мэдээллээр бусдыг гутаах;

4.2.23. Байгууллагын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн, хувийн үзэл бодлын үүднээс сөргөөр тайлбарласан, олон нийтийн хүртээл болгоогүй аливаа мэдээлэл болон хувь хүнтэй холбоотой мэдээ, мэдээлэл тараах;

4.2.24. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сошиал сүлжээг ашиглан төр, засгийн бодлоготой холбогдсон асуудал, дээд удирдах байгууллагын үүрэг, чиглэлийг эсэргүүцсэн мэдэгдэл, байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлөх мэдээ мэдэгдлийг нийтлэх;

4.2.25. Үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох үйлдэл хийх, соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;

Тав. Ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх ажиллагаа

5.1. Улсын Филармони нь ёс зүйн дэд хороотой байх ба уран бүтээлч, ажилтныг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх төлөвлөгөө гарган баталж, шаардагдах төсвийг төсвийн шууд захирагчаар батлуулж ажиллана.

5.2. Улсын Филармонийн ёс зүйн дэд хороо нь Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу ажиллана.

5.3. Уран бүтээлч, ажилтны ёс зүйг сахин биелүүлэх нь байгууллагын удирдах албан тушаалтны өөрийн биеэр үлгэрлэн манлайлах явдал болно.

Зургаа. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

6.1. Энэ дүрмийн 4 дүгээр зүйлд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг ёс зүйн зөрчилд тооцно.

6.2. Улсын Филармонийн Ёс зүйн дэд хорооны ёс зүйн зөрчил гаргасан тухай дүгнэлтэд үндэслэж Захирлын шийдвэрээр ёс зүйн хариуцлагыг ногдуулна.